МОНГОЛ ОРОСЫН ХАРИЛЦААНЫ ТҮҮХЭН СУРГАМЖ

Л.Дугаржав*

Оршил

Говь талын малчны гэрт бойжиж ботго тугал эргүүлж, адуу тэмээнд давхиж өссөн малчны хүү миний бие Москвад суралцахаар явсан үеэсээ эхлээд 40 шахам жил оросуудтай хамтран ажиллаж байна. Үүний зэрэгцээ Орос Монголын харилцааг олон жил ажиглаж, цаг л гарвал энэ талаар уншиж, уулзаж учирч явсан хүмүүсийнхээ бодол санааг зориуд сонирхон сонсож, судалгаа хийж явна. Энэ удаа би өөрийнхөө санал бодлоо, эгэл жирийн монголчуудынхаа ойлголттой жишиж тунгаан, уншигч олондоо толилуулж байна.

Түүхэн уламжлал

Эцэг өвгөд маань оросуудын тухай ярихдаа: "Ах нар гундуугүй, ханилгаа сайтай улс" гэж ам сайтай байв. Оросууд нүнжигтэй гэдгийг хөдөөний хөх өвгөдийнхөө амнаас анх сонссон. Энэ бол түүхэн хувь заяаны эрхээр олон олон зууны турш хаяа залган нутаглаж ирсэн орос монголын ард түмний хөршийн харилцааны гол үнэлгээ нь юм. Орос Монгол хоёр бол хөрш залгаа газар нутаг, байгаль цаг уурын ижил төсөөтэй нөхцөлд олон зууны туршид өгөө аваатай ажиллаж амьдарч, айл зэргэлдээ оршиж, түүхийн эгзэгтэй үеүдэд цэрэг улс төрийн хувьд холбоотой байсан төдийгүй, хүн ам нэлээд нь мах цусны барилдлагатай болж, хэл, соёл, зан заншлаас эхлээд нийгэм эдийн засгийн хөгжлийн салбарт ч тал талдаа өргөн харилцан нөлөөлж ирсэн онцлог түүхэн уламжлалтай хоёр орон.

Орос орон 240 жилийн турш Монголын эзэнт гүрний хараат байх үед Александр Невский тэргүүтэй зарим вангууд монголчуудтай цэрэг улс төрийн холбоо тогтоон, баруун европын түрэмгийллээс эх орноо хамгаалж, Оросын үнэн алдартны сүм хийдүүд ч монголчуудыг дэмжиж байсан төдийгүй, шуудайд хийсэн ямааны эвэр шиг өөр

*Л.Дугаржав - Г.В.Плехановын нэрэмжит ЭЗИС-ийн салбарын нэгдүгээр орлогч захирал, түүхийн шинжлэх ухааны доктор (Sc.D)

хоорондоо тасралтгүй өрсөлдөн тэмцэлдэж байсан оросын жижиг Вангуудын дотоодын зөрчилдөөн эцэслэж, Европ, Азийг дамнасан энэ өргөн уудам нутагт Монголын эзэнт гүрнийг залгамжлан Москвагийн вант улсаар толгойлуулсан хүчирхэг нэгдмэл Орос орон, хожим нь зөвлөлтийн эзэнт гүрэн дэлхийн түүхийн тавцан дээр гарч ирсэн түүхтэй. Энэ талаар Октябрийн хувьсгалаас өмнө ч, хойно ч Н.М.Карамзин, В.И.Вернадский, Л.Н.Гумилев, Эрежин Хар-Даван зэрэг оросын эрдэмтэн судлаачид цагийн цагт бичсээр иржээ.

Өнөөдөр ч ОХУ-ын бүрэлдэхүүнд багтдаг, монголчууд бидний тасарсан мах, үсэрсэн цус Буриад, Халимаг, Алтайн хязгаар, Тувагийн ард түмэн гээд нэг сая орчим монгол угсаатнууд маань монгол хэл, түүх, соёл ёс заншлаа хадгалан, үнэхээр эцэг өвгөдийнхөө гал голомтыг гэсэн элгэн халуун сэтгэлээр Орос, Монголыг эгнэгт холбох гол шижим болж, нулимстай нүдээр наашаа харж явна шүү дээ.

Алтан ордны улсаас тасран гарсан Крым, Казань, Астрахань, Сибирийн хаант улсуудын нутагт оршин суугаа орчин үеийн татаруд, кавказын зарим хэсэг, Саха улс зэрэг оросын зарим бүс нутгийн хүн зон нь түүх, хэл соёл, зан заншлын хувьд монголчуудтай нийтлэг олон шинж чанарыг хадгалж үлдсэн, урьд ч, эдүгээ ч орос монголын харилцааг хөгжүүлэх өөриймсөг сонирхолтой, монголчуудад бусдаасаа илүү элгэмсэг ханддаг халуун дотно сэтгэлийг нь монголчууд бид анхааран хүндэтгэж, монгол хүнийхээ чин сэтгэлээр угтан найрсаг нөхөрлөж явбал сайхан бөгөөд ийм ах дүүсэг анд нөхдөөсөө нүүр буруулах нь монгол ёс бишээ. Оросын томоохон эрдэмтдийн ихэнх нь еврей, эсвэл татар гаралтай байдаг нь ч учиртай.

Оросын туульсын их зохиолч Лев Толстой нэгэнтээ "Цусанд чинь монгол хольц байхгүй бол, чи ямар юмных нь орос хүн байх вэ" гэсэн гэдэг. Оросын төр, цэргийн нэрт зүтгэлтнүүд, эрдэмтэд, урлаг, соёлын алдартнуудын дотор монгол угсаа гарлын хүмүүс олон байжээ. Тэдгээрээс цэргийн нэрт жанжин М.Кутузов, октябрийн хувьсгалын удирдагч В.И.Ленин, эрдэмтэн, зохиолч Карамзин, Гумилев, Павлов, Тимирязов, Тургенев, Достоевский, Державин, Менделеев, Плеханов гээд олон хүнийг нэрлэж болно. Монгол, Оросын харилцаа, хэлхээ холбоо нь ийм холын үндэстэй, удам угшлын нягт сүлбээтэй ажээ.

Найрамдлын оргил үе

1921-1991 оны Монгол улсын түүх бол Монгол Оросын ард түмний найрамдал, хамтын ажиллагааны үр шимээр манай орон сэргэн мандсан, хэн ч няцааж, үгүйсгэж чадахгүй бодит үнэн түүх билээ. Намайг Эрдэнэдалай сумын сургуулийн хоёрдугаар ангид сурч байхад

"Орос Монголын найрамдал
Одноос хурц гэрэлтэй
Олон монголын ардад
Онцын халуун ачтай" хэмээн цээжлүүлж, хүүхдүүд нийтээрээ дуулдаг байсан нь санаанд тод үлджээ.

Монгол, Оросын найрамдлын шинэ хуудсыг большевикууд ч юм уу, 1921 оны хувьсгалчид нээчихсэн юм биш бололтой. Монголын түүхийн дундат үеийн баримт сэлтээс ажиглахад хоёр орны харилцаа, ялангуяа монголчуудаас оросыг түшиглэн ханьсах санаа, сэдэл, үйл ажиллагаа нэлээд дээр үеэс эх үндэстэй нь илт мэдрэгдэнэ. XVII зууны үеэс Манжийн түрэмгийллийг эсэргүүцсэн Монголын тусгаар тогтнолын төлөө тэмцлийн үед Сэцэн хан Шолой Москватай элчин солилцож, анхдугаар богд, өндөр гэгээн Занабазар хүртэл хойд их хөрштэйгөө эв найртай аж төрөхийг чухалчилж, Орос Халхын хоорондын зөрчил зөрөлдөөнийг эвээр зохицуулахад шууд биечлэн оролцож байжээ. Чухам халимагууд, буриадууд Орост дагаар орсон нь энэ цаг үетэй холбоотой.

Манжийн эсрэг Зүүн гар, төв Халхын бослогын удирдагчид Амарсанаа, Чингүнжав нар ч Орост эцсийн найдлага тавьж, тусламж авахаар тэмцэж яваад үрэгдсэн билээ. Ийнхүү өндөр өвөг дээдэс маань түүхэндээ үхэх сэхэхдээ тулсан эгзэгтэй хүнд цагт умар зүгрүү харж, Орос орныг найдвартай түшиг тулгуураа гэж тооцож байсныг түүх батална.

XIX, XX зууны зааг үед Монгол эх орноо Манжийн дарлалаас чөлөөлж үндэснийхээ тусгаар тогтнолыг сэргээх гэсэн тэмцлийнхээ явцад VIII Богд Жавзундамба болон Чин ван Ханддорж, Сайн ноён хан Намнансүрэн нарын ихэс дээдэс маань ихээхэн хүчин зүтгэл гаргаж, удаа дараа их оросын хүчин дэмжлэгт түшиглэсэн нь шийдвэрлэх үүрэг гүйцэтгэжээ. Дараа нь хятадууд Монголын автономит засгийг устгаж, Монголд өөрийн цэрэг улс төрийн харгис дэглэмээ тогтоосон үед Монгол орныг оросууд л чөлөөлж, бие даасан Монгол улс өнөөдрийнхээ хилээр үлдсэн. Богд хаант Монгол улсаас алс холын Америк, арлын Япон гэвч чамгүй олон оронд хандсан боловч аль ч улс нь тэр цагт монголчуудын санал

мэдэгдэлд хариу өгөөгүй шүү дээ.

1921 оны хувьсгал бол тусгаар Монголыг дэлхийн түүхийн тавцан дээр оросын тусламжтайгаар хадгалж үлдэх тэмцлийн шийдвэрлэх алхам байсныг үгүйсгэвэл нүгэл болно. Энэ бол монголчууд тэнгэртэй босоо заяатай, цаг үеийн мэдрэмж сайтай, гүйлгээ зөв ухаантай ард түмэн гэдгийг баталсан ховор түүхэн цаг үе, үүлэн чөлөөний нар байжээ. Бидний азаар Оросын шинэ төр засгийн удирдагч нь халимаг монгол угсаа гаралтай, суут Ленин байж таарчээ. Уг нь В.И.Ленин Монголын тусгаар тогтнолыг аварч үлдсэнийхээ төлөө манай оронд нэг байтугай хөшөө дурсгалтай байж болох хэн ч маргахааргүй түүхэн гавьяатай хүн.

XX зууны эхэнд 600-гаадхан мянган хүн амтай, харанхуй бүдүүлэг, хоцрогдсон буурай Монгол орны талаар барууны хэвлэлүүдэд "Мөхөж яваа улс, үндэстэн" гэж олзуурхангүй бичиж байж. Иймэрхүү улс орныг сэргээн өндийлгөх, нийгэм эдийн засаг, соёлыг шинээр хөгжүүлэхэд оросуудын гар бие, тусламж дэмжлэг оролцоогүй тийм салбар байхгүй. Юуны өмнө хүн амыг нь гэгээрүүлэх, эрүүлжүүлэхээс тусламжаа эхэлсэн. Анхны сургуулиудад ялангуяа дээд сургуульд нь зөвлөлтийн багш нар уригдан ажиллаж, Гэгээрлийн яамны анхны сайдаар Н.Ф.Эрдэнэбатуханов ажиллаж, МУИС 1960 он хүртэл орос хэл дээр хичээллэж байсныг боддоо. 1920-иод оноос зөвлөлтийн их дээд, тусгай мэргэжлийн дунд сургуулиудад монголын олон арван мянган хөвгүүд охид явж суралцах онцгой сайхан боломж олгож байсны ач холбогдол, үр өгөөжийг үнэлж баршгүй, орос монголын харилцааны хамгийн үнэтэй хөрөнгө оруулалт байлаа. Монгол улс түүхийн богино хугацаанд орчин цагийн боловсролтой, соёлтой орны зиндаанд хүрч, 1970-аад онд ЮНЕСКО-гийн өргөмжлөл хүртсэн.

Монголчуудыг толгой дараалан эрүүл мэндийн үзлэгт оруулж, шаардлагатайг нь албадан эмчилгээнд хамруулснаар хүн ам эрүүлжиж, 60-аад жилийн дотор манай хүн ам дөрөв дахин өссөн нь оросын ард түмний тусламжийн хүч. Манай оронд европ эмнэлэг байгуулж бэхжүүлэхэд гурван үеэрээ зүтгэсэн П.Н.Шастин, хувьсгалын эсэргүү босогчдоос шархтнуудыг хамгаалж яваад амь үрэгдсэн Немой, тарваган тахлын голомтоос гурван настай хүүхдийг амь насаараа дэнчин тавьж аварсан Л.С.Соболева нарын зэрэг зөвлөлтийн олон эмч нарын алдар гавьяа Монгол оронд домог болж мөнхөрсөн.

"Хэрвээ оросуудгүй байгаагүй бол манай Монгол гэж өдийд байхгүй болсон байх байсан, нэг биш удаа бидний аминд орсон

улс шүү" гэж эгэл жирийн монгол хүмүүс ярихыг сонсоод, би хүн ардынхаа саруул ухаанд бишрдэг нэгэн.

Монгол үндэстний хамгийн үнэт зүйл манай тусгаар тогтнолыг ЗХУ бүхий л талаар, хөвгүүд охидынхоо амь нас, халуун цусаар хамгаалан авч үлдсэнийг түүх мартахгүй. Халх голын дайнд Зөвлөлт-Монголын талаас 18.5 мянган хүний хохирол амссаны дотор амь үрэгдсэн монгол цэргийн тоог 237 гэж тогтоосон. Бусад нь орос аав ээжийн хүүхдүүд байжээ.

"Хамгийн хатуу ширүүн довтолгоонд оросууд л ордог байсан" гэж ахмад дайчид дурсдаг. "Галын шугаман дээр даалгавар биелүүлж яваад илэрч, дайсны мөндөр шиг шаагих суман дундуур буцаад гүйхэд, архан талд ах нар давшиж ирээд гишгэх газаргүй хориглон хэвтчихсэн байхыг харахад мөн ч сайхан байсан" гэж манай нутгийн ахмад дайчин хув хэмээх Чимэд гуай нулимс унаган ярьж суудагсан. Халх голоос дэлхийн II дайны хамгийн алдарт жанжин Г.К.Жуков анх тодорч, чухамхүү Их Чингисийн өлгий нутгаас ялан дийлэхийн өлзий хутаг нь бүрдсэн байх гэж бодогдоно.

Зөвлөлт эх орны их дайны эхний өдрөөс эхлэн хэдэн жилийн хүнд цаг үед БНМАУ, монголчууд зөвлөлтийн талд баттай зогсож юу байдгаараа чин сэтгэлээсээ тусалж нөхрийн чанараа харуулсныг оросын ард түмэн мартаагүй байдаг нь таатай. Ялалтын баярыг манайхан бараг оросуудаас дутахгүй тэмдэглэдэг нь ч учиртай. Дэлхийн II дайнд ялсан ЗХУ-ын санаачилга, хүчин чармайлтын үр дүнд Монголын тусгаар тогтнолыг эхлээд Хятад улс, дараа нь олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрч эхэлсэн билээ.

Манай орны уламжлалт мал аж ахуйгаас бусад аж үйлдвэр, барилга, газар тариалан, тээвэр холбоо, геологи хайгуул, уул уурхай, түлш эрчим хүч, сургууль соёл, урлаг спорт гэсэн эдийн засаг соёлын бүх салбарыг цоо шинээр бий болгон хөгжүүлэх асуудлыг зөвлөлтийн санхүү эдийн засгийн дэмжлэг, техник тоног төхөөрөмж, зөвлөлтийн мэргэжилтнүүдийн голлох оролцоотойгоор шийдвэрлэсэн юм. Зөвлөлтийн мэргэжилтэн туслаагүй, ажиллаагүй тийм салбар байхгүй. Орос ахыгаа дагаж жирийн малчны хүү Ж.Гүррагчаа сансарт ниссэн нь манай хоёр орны ах дүүгийн найрамдлын оргил үе байлаа. Орос хүний эгэл боргил гүндүүгүй зан чанар, нөхөрсөг, өгөөмөр сэтгэл, ажил мэргэжилдээ үнэнч үлгэр дууриал, монголчуудад ойр дотно, өөриймсөг зан чанарыг нь монголчууд үнэлж, "Ах нар" гэж эрхэмлэн хүндэтгэж ирсэн уламжлалаа өнөөдөр ч хадгалсаар байна.

Монголчууд үнэн сэтгэлийн бахархал хүндэтгэлийн

илэрхийлэл болгож хүүхэдлээ Ленинээс эхлээд оросын төр, цэргийн алдартнуудын нэрийг өгсөн байдаг. Хятад ч юм уу, япон, америк нэрийг урьд ч, одоо ч өгөөгүй л байна шүү.

Зөвлөлтийн хөрөнгө оруулалт, тусламж нь хөнгөлөлттэй зээл, хүүгүй зээл, буцалтгүй тусламжийн хэлбэрээр чин сэтгэлийн, сэтгэл харамгүй шинжтэйгээрээ онцлог байсныг тэмдэглүүштэй. Миний л мэдэх оросын, зөвлөлтийн зээл тусламжийг 1921, 1934, 2003 онуудад удаа дараа тэглэж, монголчуудыг өр зээлгүйд тооцож, харж үзэж байсан.

Өнөөгийн байдал

Оросууд монголчуудад зориулан үнэхээр олон зүйлийг барьж бүтээж өгөхдөө бөх бат, нэг байтугай насны үнэнч юм хийж байсан болохоор, одоо ч тэдгээрийн нэлээд нь бидний амь амьдралыг залгуулсаар л байна. Орос ах нарынхаа гараар барьж байгуулагдсан Улаанбаатар, Дархан, Эрдэнэт, Багануур зэрэг олон хот суурингуудад, сургууль, цэцэрлэг, эмнэлэг,орон сууцны олон мянган барилгуудад манай хүн амын тал илүү нь амьдарч, сургууль, эмнэлгүүдэд нь үйлчлүүлсээр байгаа нь маргашгүй үнэн.

Тэгвэл оросуудыг явснаас хойшхи 20 гаруй жилд гадаадын өнөө олон түншүүд монголчуудад зориулж хэн нь юу барьж байгуулсан билээ? Оросууд ажиллаж үлдсэн сүүлчийн голомт Эрдэнэтийн үйлдвэр, УБТЗ, Монгол Орос цветмет нэгдэл нь улсын төсөв санхүүг бүрдүүлэхэд бас ч чухал тулгуур хэвээрээ байгаа.

Амьдралын гол хэрэгцээ түлш шатахууны 70 хувь, цахилгаан эрчим хүчний хэвийн ажиллагааны баталгаа нь оросуудтай холбоотой байна.

Орост үйлдвэрлэгдсэн, өргөн хэрэглээний ижил дасал болсон бараа, таваарын яс чанарыг яахан мартаж чадах билээ, бид. Захын наймаачид хаанаас ч юм чирч авчирсан бараагаа жинхэнэ орос бараа гэж рекламдах нь сайн нэрийг гурав худалдаж иднэ гээч болж байх шиг байна.

Оросууддаа манай жирийн ард түмэн бол ер нь сайн хэвээрээ байгаа. Социологийн судалгааны дүнгээр хамгийн найдвартай түнш гэсэн асуултын тэргүүнд оросуудыг нэрлэсэн байна лээ. Монголын жирийн иргэд хаа нэгэнтээ оросууд явж байгааг мэдвэл "Манай оросууд" гэж саймширна, төрөл саднаа үзсэн мэт хөөрцгөөнө. Тусалъя, дөхүүлээд өгье, зарим нь таксины мөнгө авахгүй гэнэ. Хөдөөнийхөн бол оросуудыг хүндэт зочноо гэж угтана. Ардын ухаан ийм л агуу, түүнийг дутуу үнэлбэл алдас болно.

Харин хоёр орны албан ёсны харилцаа, хамтын ажиллагаа

нэг л зогсонги, олигтой явахаа больжээ. Ерөнхийдөө хоёр орны хамтын ажиллагааг өмнөх олон жилийн туршлагадаа түшиглэж хөгжүүлэх асар их боломж, бас багагүй хэрэгцээ байгаа ч ашиглах сонирхол эрх баригчдад алга уу даа гэж ард олон ярилцах болжээ. Улс төрийн харилцаанаас ялангуяа худалдаа эдийн засгийн харилцаа хоцорчээ. ОХУ-ын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, тус улсаас стратегийн орд газрууд тухайлбал Тавантолгойг ашиглахад хамтран оролцох, уран олборлох хамтарсан үйлдвэр барих, УБТЗ-ыг өргөтгөн шинэчлэх асуудлыг төр засгийн удирдагчдын уулзалт, Засгийн газар хоорондын хамтын ажиллагааны комиссын жил бүрийн хуралдаан болгоноор олон жил хэлэлцэж, гэрээ хэлэлцээр хийсээр байгаа ч үнэндээ эдгээр чухал асуудлыг эцэслэн шийдэж, бодитой хэрэгжүүлсэн юм алга.

Манай эрх баригчид оросуудтай ам хэлээ ололцохоо бараг болио юу даа. Сүүлийн 20 гаруй жилд Орос, Монголын харилцаанд шинээр хэрэгжүүлсэн нэг ч шинэ төслийг нэрлэж мэдэхгүй юм. Оростой харилцах асуудлыг гадаад бодлогын тэргүүлэх чиглэл, стратегийн түншийн нэг гэж тунхаглах мөртлөө монголчууд оросоос аажмаар, амжилттай холдсоор, хөрш Орос маань манайхны хувьд холын танихгүй орон болох цаг наашилсаар байна уу даа гэж сэтгэл сэмэрнэ.

Улс төр, дипломатын харилцаа л албан ёсны хэмжээнд хадгалагдаж, харин яам, салбар, орон нутаг, байгууллага аж ахуйн газрууд, хувь хүмүүс хоорондын харилцаа хумигдсаар байгаа нь их харамсалтай. Улс хоорондын харилцаа гэдэг бол хувь хүмүүс, цаашлаад байгууллага хоорондын, хил орчмын бүс нутгийн ойр дотнын харилцаа, ардын дипломатаас эхэлдэг. Бие хөндийрвөл, сэтгэл хөндийрнө гэдэг хүн ёсны харилцааны философ ч энд хамаарна.

Хөршүүдийн хоорондбайсан ойр дотно, бүр ах дүүсэг, найрсаг харилцаа нь манай эцэг өвгөдийн зуу зуун жилийн хучин чармайлтаар бэхжиж гагнагдсан, түүх, он цагийн шалгуурын ороо, бусгаа олон цаг үед давсан, асар үнэт зүйл. Харин устгаж үгүй хийх санаархал хэрэгжээд байгаа юм шиг.

Орост сургууль төгсөгчид ч 20-30 жил өнгөрөхөд эргээд Орос руу ер явсангүй, сургууль, багш нартайгаа уулзсангүй гэж харамсацгаадаг. Орчуулагчгүй бол зарим нь оросоор харьцахаас төвөгшөөж, халширдаг болох нь ээ.

Захын эмээ "Здравствуйте"-тэй байсан манайхан оросоор огт дуугарч чадахаа болих нь. Дунд сургуульд хоёрхон жил үздэг болсон

орос хэлний хичээл ялангуяа орон нутаг, хөдөөд ерөнхийдөө ор нэрийн төдий үлджээ. Орос хэл монголын дээд сургуулийн хөтөлбөрөөс хасагдсан байж. Харин манай хүн амын нэлээд хэсэг нь, ялангуяа сэхээтнүүд хүүхдэдээ орос хэл сургах, оросын боловсрол хэрэгтэй, ирээдүйтэй гэсэн итгэл найдварыг хадгалсаар байгаагийн хүчинд орос хэлээр сургалтаа явуулдаг хэдэн сургууль, Плехановын нэрэмжит Эдийн засгийн их сургууль, Дорнод сибирийн технологи удирдлагын ДС-ийн салбарууд одоогоор тогтож л байна. Орос Монголын Засгийн газар хоорондын гэрээний дагуу жил бүр ОХУ-д суралцахаар явдаг 270-аад оюутны ихэнхийг дээрх сургуулиудын төгсөгчид бүрдүүлдэг.

Орос хэл бол НҮБ-ын албан ёсны нэг хэл нь төдийгүй дэлхийн шинжлэх ухаан, соёлын ололтоос хүртэх том түлхүүр юмсан. Манай хөршийн орос хэлээр энэ гаригийн 600 сая хүнтэй харилцаж болдог, монголчуудад бол зөвхөн гэртээ байхад төдийгүй Сингапурт ч, Америкт ч, Японд ч очсон орос хэл их хэрэг болдог, зарим үед аминд нь ордог амьдралын амьд жишээ олныг сонссон.

Манайд ирэх болсон хамтаръя, тусалъя, олз ашиг хүртье гэсэн олон хэлийн амьтдын дотроос оросуудтайгаа арай өөриймсөг, учиртай ханддаг монгол хүний ноён нуруу хадгалж үлдэх юмсан. Айл хүний амь нэг гэсэн эцэг өвгөдийн алтан сургаалтай билээ бид.

Цаашдын хандлага

Хоёр улсын харилцаа аль алинаасаа хамаарах нь ойлгомжтой. Орос Монголын харилцааг хайхрахаа больж зөнд нь орхивол манай орны хувьд илүү хохирол үзэж, тусгаар тогтнол, аюулгүй байдлын чухал баталгаагаа алдаж болох юм.

Төр засгийн дээд удирдлагын түвшинд албан ёсны харилцаанд оросуудыг тоохоо болих, хэлж тохирсноо хөсөрдүүлж итгэл алдах, хөндийрөх, өө сэв эрээд ч байгаа юм шиг, зөвлөлтийн үеийн хамтын ажиллагааны түүх, үйл явдлыг нэхэн залруулах муйхар санаархал, үг яриа гарах болсон нь Монгол улсын үндэсний эрх ашигт нийцэхгүй ээ. Энэ нь манай монголын зон олны язгуур эрх ашиг, хүсэл сэтгэлтэй зөрж байгаад хэргийн учир оршино. Үүнд Монгол улсын иргэний хувьд би санаа зовж, ичиж, бас их харамсаж байна.

Манай хоёр том хөршийн нэг, өнөөдөр дэлхийн хүчирхэг гүрэн Орос оронтой монголчууд олон зууны туршид ойр дотно харилцаж, өгөө аваатай явж ирсэн, гай зовлон хэлж ирэхгүй, хийсч ирдэг, зовж зүдэрсэн цагт оросуудл бидэнд ойр дөт байж, авралын гараа сунгадгийг сүүлийн зуун жилийн түүх сануулсаар байна шүү.

Монголчууд бол туйлбартай, хүлээцтэй, өөрийн уудам тал

нутаг шигээ уужим саруул ухаантай ард түмэн юмсан. Бид саяхан болтол орост яаж сүйд болж байлаа, одоо ямархуу нүүр царайтай хандаж байгааг дэлхий даяараа ажиглаж л байгаа. Уулын буга хараад, усанд унасан бухаа хаяж, гуравдахь хөршийг мөрөөдөн ийш тийшээ учиргүй хөл алдан гүйцгээж, хүндээ хөнгөнөөс өгч боломгүй.

Гадаадын ямар ч улс Монголтой харилцахдаа, хөрөнгө оруулахдаа өөрийн үндэсний эрх ашиг, сонирхолтой байж л таарна. Америк ч, Япон ч, Хятад ч тус бүртээ өөр өөрийн сонирхолтой. Эдгээрээс Оросын сонирхол монголчуудад өлзийтэй байж болох нь олон зуун жилийн туршид нэгэнт нотлогджээ. Дээлийн шинэ нь нөхрийн хуучин нь дээр гэж сургадаг ард түмнийхээ мэргэн ухаанд залбирья.